

ТАЛХ ЧИХЭР ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үйл ажиллагааны тайлан /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2023.1.1-2023.12.31
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Талх Чихэр”ХК, Гэрчилгээний дугаар 9010001092, ТСК,С10, 99107023
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж”ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,023,703 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Д.Эрдэнэцэцэг СХА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч

1.Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав
Орлогын тайлан	Тайланг хавсаргав
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав
Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав

1.1 Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

Жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт : Компанийн борлуулалтын орлого өссөн, ажилчдын цалин орлогыг нэмэгдүүлсэн, тоног төхөөрөмжийн шинэчлэлт болон ажилчдын ур чадварыг сайжруулах мэргэшүүлэх зорилгоор сургалт хөгжүүлэлтэд голлон анхаарч ажиллажээ.

2 . Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурьдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх / нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

Хэдийгээр импортоор авдаг материалын зардал, тээврийн зардал, ханшын өсөлт нэмэгдсэн боловч тайлант үеийн санхүүгийн байдлаар авч үзэхэд борлуулалтын орлого, нэмэгдсэн, ажилчдын цалин, орлого 30-40% нэмэгдсэн , ажилчдын ур чадварыг сайжруулах, мэргэшүүлэх, туршлага судлуулах зорилгоор ази, европын орнуудад үзэсгэлэн худалдаанд удаа дараалан оролцуулсан, компаниас дэвшүүлсэн зорилт төлөвлөгөөг биелүүлэхэд сургалт хөгжүүлэлтэд болон тоног төхөөрөмж шинэчлэхэд голлон анхаарсан үзүүлэлттэй сайн ажиллажээ.

2.1.Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	
2.2.Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө бараа материалын үлдэгдэл хангалттай байгаа нь хөрвөх чадвартай хөрөнгө хүрэлцээтэй , төлбөрийн чадвар сайн байгаа үзүүлэлт юм.

2.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Үйлдвэрлэлийн зардлыг зохих түвшинд барьж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж түүхий эдийн нөөцийг хангалттай байлгах, ажилчдыг чадваржуулах, санхүүгийн чадварыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн
2.4. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
2.5. Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	ХХБанкнаас ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 1.465,345,709₮-ийн зээлд 1 үл хөдлөх хөрөнгө барьцаалуулсан болно. Тайлант хугацаанд өмнөх зээлийн үлдэгдэл хуваарийн дагуу мөн тухайн онд авсан зээлээс 2.643,754,928₮-ийг төлсөн болно.
3. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Их хэмжээний хэлцэл хийгдсэн	
4. Цалин урамшууллын мэдээлэл	
Тус компани нь 2023 онд ТУЗ-ийн гишүүдийн цалинд 66,550,0₮ийн цалин, Гүйцэтгэх захиралд 33,430,035₮-ийн цалин урамшуулал олгожээ.	
5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
Тус компанийн ТУЗ нь ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн, нийт 9 хүний бүрэлдхүүнтэй ажилласан бөгөөд Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын, Аудитын гэсэн хороодтой ажиллалаа. ТУЗ нь компанийн засаглалын кодексын хэрэгжилтэд ихээхэн анхаарч ажиллаж СЗХорооноос 104 хувьцаат компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг дүгнэн байр эзлүүлсэн жагсаалтад 28-р байр эзэлсэн үзүүлэлттэй ажилласан байна.	
6. Зах зээлийн эрсдлийн мэдээлэл	
Манай компани нь хүнсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд одоогоор 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ТОП 100 аж ахуйн нэгжийн нэг юм.	
7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл / 5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо /	
1.	Х.Баттуул-340.000ш хувьцаа буюу-33,22%
2.	Х.Баттулга-193.886ш хувьцаа буюу-18,94%
3.	Х.Цэндбаяр-195.901ш хувьцаа буюу-19,14%
4.	Б.Эрхэс-146.390 ш хувьцаа буюу 14,3%
8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
Байхгүй	
9	Ногдол ашгийн мэдээлэл

	<p>Манай компани нь 2022 онд нэгж хувьцаанд 350₮-ийн ногдол ашиг, 2023 онд нэгж хувьцаанд 400 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар ТУЗ-ийн тогтоол гарсан бөгөөд 2023 онд 5,875,514 төгрөгийн ногдол ашиг тараасан байна.</p>	
10	<p>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл:</p>	
10.1	<p>17-р жарны Үзэсгэлэнт болгогч хэмээх Харагчин туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан "Талх Чихэр" ХК үе үеийн алтан хэлхээ болсон ахмад ажилчдаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.</p>	
10.2	<p>“Мөрөөдөл бидний ирээдүй ТА ЧИ ” хүүхдийн баярын арга хэмжээг компанийн нийт ажилчдын хүүхдүүдийн дунд зохион байгууллаа.</p>	
10.3	<p>"Талх Чихэр" ХК нийгмийн хариуцлагын хүрээнд СХД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин СХД-ийн ЗДТГ, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төвтэй хамтран “ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА” зохион байгуулсан.</p>	

10.4 "Талх Чихэр" ХК жил бүрийн сар шинийн баярын өмнө Хөдөлмөрийн баатруудаараа бахархан хүндэтгэл үзүүлж, алдаршуулдаг уламжлалтай.

Уг уламжлалын дагуу малчны хот, хөнгөн үйлдвэрийн цех, уул уурхай, урлаг, спорт гээд бүхий л салбараас өөрийн ажил хөдөлмөр хичээл зүтгэлээ төр засаг, түмэн олноороо үнэлүүлж, төрийн их хайр хишгийг хүртсэн эрхмүүдээ хүндэтгэл үзүүлэх уг арга хэмжээг "БААТРУУДААРАА БАХАРХЪЯ" нэрийн дор 9 дахь жилдээ ийнхүү амжилттай зохион байгууллаа.



10.5 "Амтлаг аялал" нэрийн хүрээнд Улаанбаатар хотын 10 жилийн сургууль, хамтран ажиллагч байгууллагын 1000 гаруй хүүхэд багачуудад үйлдвэрийнхээ үйл ажиллагааг танилцуулсан байна. Аялалд оролцсон хүүхэд бүртээ бид #Амтлаг брэндийнхээ бүтээгдэхүүний дээжийг бэлэглэсэн билээ.

Мөн БГД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран Зэвсэгт хүчний 120-р ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл шинэхэн Атар талх, Та Чи нарийн боов, Delice pastry брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйл ажиллагаатай танилцсан.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монголын ардчилсан холбоо, "Genco Tour Bureau" ХК-тай хамтран зохион байгуулсан аяллын хүрээнд Улаанбаатар хот, 21 аймгийн 300 гаруй хүүхэд багачууд үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцсан.



10.6 Үндэсний үйдвэрлэгчдийн "Баялаг бүтээгч-Business" тур 4 дэх удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж, 50 гаруй үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл "Талх Чихэр" ХК-ийн үйл ажиллагаатай танилцсан. Тэр дундаа талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч "Алиман сар" ХХК, "Өгөөж чихэр боов" ХХК, "Жинтуул" ХХК, "Батбайгаль" ХХК, "Тэнгэрийн хишиг" ХХК зэрэг аж ахуй нэгжүүд туршлага солилцох зорилгоор ийнхүү хүрэлцэн ирсэн нь бидний хувьд нэр төрийн хэрэг юм.



10.7

Монголын уртын дууны холбооны 20 жилийн ой, Уртын дууны "Өнө" чуулгын 10 жилийн ойг тохиолдуулан Азийн хотуудын ардын урлаг, гар урлалын "Asia Folk-2023" наадмын хүрээнд монголын үе үеийн төлөөлөл болсон 300 уртын дуучин нэг дор чуулж, ургах нарыг уртын дуугаараа угтсан түүхэнд бичигдэх гайхалтай үйл явдлыг дэмжин, хамтран ажилласан билээ.



10.8

Нийгмийн хариуцлагын хүрээнд Тээврийн цагдаагийн газраас зохион байгуулсан “Нэг зам Нэг соёл” аяныг дэмжин ажиллаж, амралт зугаалгын 1 сарын хугацаанд аяны стикерийг бүтээгдэхүүн дээр байршуулан ажиллав.



10.8

Өвлийн улиралд зохион байгуулагддаг арга хэмжээг төрөлжүүлэх, гэр бүлээрээ, найз нөхдөөрөө амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Сантатай шинэ жил” арга хэмжээг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Мөн борлуулалт, түгээлтийн автомашинуудаа гэрлээр чимэглэсэн стресс ихтэй нийгэмд гэрэл гэгээ нэмсэн онцлох үйл явдал болсон билээ.

